




## САВХАН БҮЖГИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨР ХҮҮХДИЙН БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

/Өвөрмонголын таван насны хүүхдийн жишээн дээр/

Г.Заяабат<sup>а</sup>, ЗНАО.НАЙYING<sup>б</sup>

<sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль;

<sup>б</sup>Өвөр Монголын Хөх хот, цэцэрлэг

Холбоо барих зохиогч: zasaba@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Бүтээлч сэтгэлгээ гэсэн нэр томъёо боловсрол судлалд олон арван жил хэрэглэгдэж ирсэн боловч бүтээлч сэтгэлгээг янз бүрийн салбар, мэргэжлийнхэн өөр өөрийнхөөрөө ойлгож, олон янзаар тайлбарладаг. Америкийн боловсролын философич Жон Бэн (John Bean) бүтээлч сэтгэлгээ нь хүүхэд асуудлыг дэвшүүлэн харахаас эхэлдэг гэж үздэг (Батдэлгэр, 2020)

Бүтээлч санаа нь заавал анхдагч байх ёстой бус хэний ч үзэл бодол хэний ч үзэл санааг авч болно. Харин өөрийнхөө бодлыг нэмж хэлэх нь тухайн хүний бие даасан байдал нэмэгдэхийн үндэс юм. Сэтгэл судлаачид хэвийн хөгжилтэй бүх хүүхэд бүтээлч чадвартай байдаг гэж үзсэн байна. Оюуны өндөр чадвартай хүн бүхэн бүтээлч чадвартай байдаггүй. Харин түүнийг нээж хөгжүүлдэг. Тийм учраас бага насны хүүхдийн сэтгэцийн процесс нь хэрхэн хөгжиж байгааг мэдэж болно. Хүний хөгжил хүүхэд эхийн хэвлийд байх үеэс эхлэн намуун зөөлөн хөгжим сонсох нь чухал гэдгийг эрдэмтэд нотолсон байдаг. Хүний хөгжлийн суурь үндэс нь хүүхэд юм. Хүүхдийн хөгжлийн онцгой үе болох бага насны хүүхдийн хөгжил нь бие бялдар, эрүүл мэнд, оюун ухаан-танин мэдэхүй, нийгэмшихүй, сэтгэл хөдлөл бүхий олон талт цогц ойлголт юм. Хүүхдийг бүжиглэх явцад бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх ямар боломж, шийдэл байна вэ?, Бүтээлч сэтгэлгээний аргыг хэрэглэснээр хүүхдийн хөгжилд ямар ахиц гарах вэ? гэсэн асуудал бидний гол анхаарлыг татаж ирсэн (Ветлугина, 1983). Ийм учраас хүүхэд төрсөн цагаасаа эхлэн, хүрээлэн буй орчны төсөөлөл, олж авсан мэдлэгээ сэргээн санаж, хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаанд бүтээлчээр хандан, ардын бүжгээр бүжиглэж чаддаг эсэхийг тодруулах үндсэн дээр энэхүү өгүүллийг боловсрууллаа.

### Түлхүүр үг

Бүтээлч байдал, савхан бүжиг, хүүхдийн хөгжил, хөдөлгөөн, чадвар, хөгжим сонсох

## Удиртгал

Хүүхдийг гоо сайхны ертөнцтэй танилцуулж, гоё сайхныг мэдүүлэхэд сургуулийн өмнөх нас хамгийн зохистой үе байдаг. Урлаг, уран сайхны янз бүрийн төрлөөр дамжин бүтээлч чадварыг илрүүлж, сайн муу, сайхан муухайг танин мэдэж, ойлгодог. Ийм ч учраас СӨНХ-ийн хөгжмийн хичээл үйл ажиллагаа нь хүүхдэд шинжлэх ухааны үндэслэлтэй, систем дэс дараатай өргөн хүрээтэй, урлаг гоо зүйн боловсрол эзэмших мэдлэг, чадвар, дадлыг олгоно (Лхагвасүрэн, 1985,х.15). Ийнхүү эрдэмтдийн онол арга зүйд тулгуурлан “Савхан бүжгийн хөдөлгөөнөөр” цэцэрлэгийн таван насны хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг судлах зорилго тавьсан юм.

ӨМӨЗО-ны бүжигчин Митегмаа “Монгол бүжиг” гэдэг номондоо хүүхдийн бүтээлч чадварыг хүмүүжүүлэхэд хөдөлгөөн чухал гэж дурдсан байдаг. Жишээлэхэд, “айзам цохилгын хөдөлгөөн”, “морин алхам”, “нэг хөлөөрөө догонцож үсрэх” г.м хөдөлгөөнийг хүүхэд сурсан байдаг. Жишээлэхэд, хүүхэд өөрийн үзэж өнгөрсөн морин гүйлтийн дөрөөг холбон бодож төсөөлж дахин шинээр бүтээдэг. Багшийн үлгэр дуурайлал хөдөлгөөнийг сонирхох ба “морин гүйлт”-ийн үндсэн хөдөлгөөнийг сурч эзэмших явцад хүүхдүүд өөрийн үзэж өнгөрсөн “морин гүйлт”-ийн хөдөлгөөн ба сэтгэлгээний өнгөрөлтийн дараах амьдлаг морины гүйлтийн дүрээ нилээд боловсронгуйгаар хийж гүйцэтгэдэг. Харин зарим хүүхдүүд яагаад хүний өөдөөс хараад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй, бүрэг ноомой болоод байна вэ? Энэ бүхэн зарим эцэг эх, багш нарын арга барилтай холбоотой юм. Хүүхдийг багаас нь өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн, сэтгэн бодож, сургахын тулд хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шаардлагатай болох нь практикаас харагдаж байна ([https://creativecommonsclub.blogspot.com/2012/11/blog-post\\_18.html](https://creativecommonsclub.blogspot.com/2012/11/blog-post_18.html), 2012). Бүтээлч сэтгэлгээ гэдгийг ухаан, ухамсар сэргээх, хөгжүүлэх гэсэн ойлголтод хамааруулж авч үздэг. Йеэлийн их сургуулийн профессор Самнер (1906) бүтээлч сэтгэлгээ бол аливаа төсөөлөл (таамаглал) бодит байдалтайгаа аль хэр нийцэж байгааг шалгах хэрэгсэл мөн гэж ойлгоод, түүнийг зааж болно. Бүтээлч сэтгэлгээ нь сургах үйл явцын бүтээгдэхүүн бөгөөд оюуны үйл ажиллагааны дадал, хүч чадал болно гэж бичсэн байна. Гэсэн хэдий ч багагүй хугацаа өнгөрч байж дөнгөж XX зууны 60-аад оноос боловсролын бодлого тодорхойлогчид бүтээлч сэтгэлгээний агуулгыг нухацтай авч үзэж, түүний үзэл санааг ойлгон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах болсон ажээ.

Сургуулийн өмнөх нас бол бүтээлч сэтгэлгээг судлахад хамгийн их анхаарал хандуулдаг бөгөөд үүнийг хөгжүүлэхэд Запорожец,А.В., Леонтьев,А.Н., Поддяков, Н.Н., Венгер,Л.А., Дружинин, В.Н., Дьяченко, О.М., Богоявленская, Д.Б., Матюшкин, А.М., Кудрявцев,В.А., Лейтс, Н.С., Хеллер,К., Гилфорд,Ж.болон бусад дотоод гадаадын олон эрдэмтэд сэтгэл судлаачдын бүтээлүүдэд бүтээлч сэтгэлгээг сэтгэхүйн бусад үйл явцаас ялгаж, хүүхдийн төсөөлөл, хувийн шинж чанартай холбоотой байдаг сэтгэлгээний өвөрмөц шинж чанар гэж үздэг (<https://minikar.ru/mn/zdorove-i-krasota/formirovanie-kreativnosti-u-detei-doshkolnogo-vozrasta-4-7-let/>). Мөн гүн ухаантан Аристотель “Философи сэтгэлгээ гайхахаас эхэлдэг” гэсэн бөгөөд бүтээлч сэтгэлгээний аргын зарчим зөв шийдэлд хүрэх арга гүн ухааны шинжтэй асуулт асуухаас эхэлдэг гэж үздэг. Ийм асуултыг бүтээлч сэтгэлгээнд

дээд түвшний асуулт гэдэг бөгөөд энэ нь бидний өдөр тутам бие биенээсээ асуудаг гол төлөв ганц зөв хариулт шаардсан асуултнаас ялгаатай. Дээд түвшний асуулт нь олон санааг тусган харьцуулж байж тайлбарлах, олон хувилбартай хариултыг шаардсан сэтгэхүйн дээд түвшний ажиллагааг илтгэсэн асуулт г.м судлаачид үзсэн байна. Иймд ардын бүжгийн хөдөлгөөнөөс “Савхан” бүжгийн хөдөлгөөнөөр дамжуулан хүүхдийн бүтээлч сэтгэлгээг судлахаар уг судалгааг хийлээ.

### Судалгааны онолын үндэс

Энэхүү судалгаанд 2022-2023 онд ӨМӨЗО-ны Шинэ хот тойргийн Монгол үндэсний хүүхдийн цэцэрлэгийн 15 хүүхэд хамрагдсан. Швейцарын хөгжмийн зохиолч, сурган хүмүүжүүлэгч Жак Далькрозын үндэслэн боловсруулсан “Хөгжимт хөдөлгөөнөөр хүмүүжүүлэх систем” олон оронд дэлгэрсэн байдаг. Түүний арга нь тусгайлан авсан дасгалуудад түшиглэн сургуулийн өмнөх наснаас эхлэн хүүхдийг хөгжмийн ой тогтоолт, сонсгол, анхаарал, хэмнэлийн хүртэх чадварыг хөгжүүлэх, уран гоё хөдөлгөөн суухад чиглэдэг гэж үздэг онол арга зүй, үзэл баримтлалд тулгуурлан уг судалгааг авсан.

Мөн хөгжим, бүжгээр хичээллэдэг хүүхдэд математик, логик сэтгэлгээ илүү төлөвшдөг ажээ. Хүүхдийн сэтгэхүйн төсөөлөл, хэл яриаг хөгжүүлэх, зан төлөвийг төлөвшүүлэн тогтоох, хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд хөгжмийн урлаг нь тэр тусмаа бүжгийн урлаг чухал хэрэглүүрийн нэг болдог (Баасанцэрэн.Х, 2008, х.30). Ардын бүжиг нь: хүүхдийн хөгжмийн мэдрэмжийг идэвхтэй хөгжүүлэх сонсгол болон эгшгийн өндөрлөг, хэмнэлийн мэдрэмжийг илүү хөгжүүлдэг байна. *Бүтээлч сэтгэлгээний тодорхойлолт.* Эргэцүүлэн бодох чадвартай, өөрийн үйл ажиллагаанд эзэн болох, үндэслэлүүдийн учир холбогдлыг ойлгох, анхааралаа төвлөрүүлж, өөртөө итгэлтэй мэтгэлцэн, гаргасан шийдвэрээ ухамсарладаг болгоход чиглэгдсэн сурган хүмүүжүүлэх шинэ аргыг бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх арга гэж нэрлэж болно. Энэ нь итгэлцлийн уур амьсгалыг бий болгож анхаарлыг сонирхолтой үзэл санаанд хандуулж учрыг нь гүнзгийрүүлэн судлахыг дэмжиж, ухаалаг маргах аргаар хангана. Шинийг бүтээнэ гэдэг нь эцсийн дүндээ шинээр сэтгэнэ гэсэн үг. Иймээс: Бүтээлч сэтгэлгээг ерөнхийд нь эерэг өөдрөг шинэлэг сэтгэлгээ, хэвшмэл биш, өвөрмөцөөр, өөрөөр сэтгэх гэж тодорхойлж болно.

Монгол ардын савхан бүжиг Ордос нутагт анх үүсэж тухайн газрын хүн ардын бодит амьдралаас эх авсан нэгэн өвөрмөц бүжгийн төрөл болно. Монголчууд нүүдлийн малжих амьдралын дундаа зүйл бүрийн бүжиг, ая дуу зохиож, өөрийн баяр баясал, бухимдал, үзэл сэтгэлгээ илтгэдэг байжээ. Түүний нэгэн савхан бүжиг юм. Анх үүсэхдээ бургас модыг атгаад амандаа ая дуу аялан айзам хэмнэлд зохицуулан бие хөл гар мөр далын дээрээ хөнгөхөн цохиж бүжиглэж байснаасаа аажмаар хуур, шагч, лимбэ, янчин зэрэг хөгжмийн зэвсгийн хавсралтайгаар дуулж бүжиглэх болсон байна.

Савхан бүжиг нь зөвхөн тойрож суугаад бүжиглэдэг байснаасаа аажмаар олон зүйлийн үйл хөдлөл нэмэгдэж баяглагджээ. Савхан бүжиг бол зугаа цэнгэлийн шинжтэй ардын бүжгийн хэлбэр байжээ. Эхэндээ голдуу ганц эрэгтэй бүжигчин бүжиглэдэг байв. Хожим нь олон хүн тойрч суугаад ардын дууны хөг айзмыг дагалдан гар мөр гуя зэрэг хэсгээ шууд тогшин бүжиглэдэг олон зүйлийн хөдөлгөөн

нэмэгдэж явган суух зогсох явах биеийн адил бус хэсгээ чөлөөтэй цохин чөлөөтэй хөдөлдөг бүжгийн хэлбэр болж хөгжсөн байна.

## Судалгааны арга зүй

Судлаачдын онол аргазүйд тулгуурлан “Савхан” бүжгийн хөдөлгөөнөөр таван настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шалгуур, үзүүлэлтийг боловсрууллаа. Үүнд:

### Хүснэгт 1. Шалгуур, үзүүлэлт

Шалгуур		Үзүүлэлт
1	Гарын хөдөлгөөн	Хос савхаа 2 гараар ээлжлэн цохиж байгаа эсэх
		Савхаа бариад хөдөлгөөнийг өөрийн санаагаар өөрчилж чадаж байвал
		Баруун зүүн гараар савхаа гадагшаа тойроглож цохих байдал
2	Хөлийн хөдөлгөөн	Зүүн, баруун хөлөө ээлжлэн өргөж үсрэх
		Хөдөлгөөнийг өөрчлөн хийж байгаа эсэх
		Өлмий дээрээ хөнгөн алхах, үсрэх байдал
3	Биеийн хөдөлгөөн	Биеийн хөдөлгөөнийг өөрийн сэтгэлгээгээр өөрчилж савхаа цохих байдал
		Нуруугаа хойш гэдийлгэж төрөл бүрийн хөдөлгөөн зохиомжлон хийвэл
		Өвдгөө хагас нугалаад 2 гуяан дээрээ савхаар цохих
4	Толгойн хөдөлгөөн	Толгойгоо гартайгаа хавсран савхаа хөдөлгөх, өөрчилж буй байдал
		Толгой доош, дээш өөрчилөн хөдөлгөөнийг зохиомжлон хийвэл
5	Ташаан хөдөлгөөн	Ташаа, гар хавсран зүүн баруун тийш хөдлөж байвал
		Орон зайн баримжаатай эсэх
		Хөгжмийн ая хэмнэлд хөдөлгөөнөө өөрчилөн хийж байгаа байдал

Хэмжээсжүүлэх:

Бүтээлчээр 1-2 хөдөлгөөн хийж байвал – 3 оноо

Хөдөлгөөнийг хувиргаж өөрчилж байвал- 2 оноо

Бүжгийн хөдөлгөөнийг хувиргах оролдлогогүй бол -1 оноо

Үнэлгээ

### Үнэлгээний түвшинчлэл

№	Оноо	Түвшин
1	30-42	Бүжгийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцох, маш их урам зориг өгөх
2	21-29	Дуртай дуулгавартай дагах, бүжгийн хөдөлгөөний бүтээлч үйл ажиллагаанд баяр хөөртэй оролцох, хийх явцдаа аз жаргалтай мэдрэмжээ илэрхийлэхийн тулд өөрсдөдөө ярих
3	10-20	Бүжгийн хичээлээс татгалзах

Судалгааны хамрах хүрээ. Энэхүү судалгаанд 2022-2023 онд ӨМӨЗО-ны Шинэ хот тойргийн Монгол үндэсний хүүхдийн цэцэрлэгийн 15 хүүхэд хамрагдсан.

## Судалгааны үр дүн


Хүүхдийн сэтгэхүйн төсөөлөлийг “Савхан” бүжгийн хөдөлгөөнөөр судалж, хүүхдийг хөдөлгөөнөөр хөгжүүлэх, зан төлөвийг төлөвшүүлэх, хүмүүжлийн нөлөө үзүүлэхэд хөгжмийн урлаг нь тэр тусмаа бүжгийн урлаг чухал хэрэглүүрийн нэг болдог гэсэн судлаачдын онол үр дүнтэй гэдгийг судалгааны явцад батлагдсан нь үр дүнтэйг илтгэж байна.

Хүснэгт 2 . “Савхан” бүжгийн хөдөлгөөнийг өөрийн бодол сэтгэлээр хийж буй байдал (шалгуур бүрээр)

№	Шалгуур	Гүйцэтгэлийн хувь
1	Гарын хөдөлгөөн хийх чадвар	80%
2	Хөлийн хөдөлгөөн хийх чадвар	93%
3	Биеийн хөдөлгөөн хийх чадвар	91%
4	Толгойн хөдөлгөөн	90%
5	Ташаан хөдөлгөөн	93.3%
	Дундаж	93%

Судалгааны үр дүнгээс харахад, таван настай хүүхдийн “Савхан” бүжгийн хөдөлгөөнийг өөрийн санаачлагаар өөрчилөн хийх чадварын дундаж үнэлгээ 93%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 1. Савхан бүжгийн гүйцэтгэл



Хөлийн хөдөлгөөн хийх чадвар 93%, ташаан хөдөлгөөн 93%, биеийн хөдөлгөөн хийх чадвар 91%, толгойн хөдөлгөөн 90%, гарын хөдөлгөөн хийх чадвар 80%-тай байгаа нь судалгаанаас харагдлаа. Судалгааны явцад бид “Савхан” бүжгийн талаар 50 хүүхдийн кейс дээр ажиллан тэмдэглэл хөтөлсөн юм.


Хүснэгт 2. “Савхан” бүжгийн хөдөлгөөний бүтээлч байдал (үзүүлэлт бүрээр авч үзвэл)

№	Үзүүлэлт	10-14 оноо	5-9 оноо	0-4 оноо
1	Хос савхаа 2 гараар ээлжлэн цохиж байгаа эсэх	9	4	2
2	Савхаа бариад хөдөлгөөнийг өөрийн санаагаар өөрчилж чадаж байвал	7	5	3
3	Баруун зүүн гараар савхаа гадагшаа тойроглож цохих байдал	3	6	4
4	Зүүн, баруун хөлөө ээлжлэн өргөж үсрэх	12	3	0

5	Хөдөлгөөнийг өөрчлөн хийж байгаа эсэх	9	5	1
6	Өлмий дээрээ хөнгөн алхах, үсрэх байдал	7	6	2
7	Биенийг баруун зүүн тийш харж савхаа цохих	8	5	2
8	Нуруугаа хойш гэдийлгэж төрөл бүрийн хөдөлгөөн зохиомжлон хийвэл	10	5	1
9	Өвдгөө хагас нугалаад 2 гуяан дээрээ савхаар цохих	9	5	1
10	Толгойгоо гартайгаа хавсран хөдлөх	6	7	2
11	Толгой доош, дээш өөрчилөн хөдөлгөөн хийвэл	9	5	1
12	Ташаа, гар хавсран зүүн баруун тийш хөдлөж байвал	6	6	3
13	Орон зайн баримжаатай эсэх	8	7	0
14	Хөгжмийн ая хэмнэлд хөдөлгөөнөө өөрчилөн хийж байгаа байдал	10	5	0
Нийт		107	81	22
%		51%	38.5%	10.5%

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээний үзүүлэлт тус бүрээр авч үзэхэд 51% нь ба 38.5% савхаа бариад хөгжмийн ая хэмнэлд хийж байгаа байдал, хөдөлгөөнийг өөрчилж байгаа байдал өндөр түвшинд байсан. Харин 10.5% бүжгийн хөдөлгөөнийг хийх оролдлого сайтай байсан ч бусдыг харах, дууриах байдалтай байсан ба хөдөлгөөнийг өөрчилж чадахгүй байсан нь харагдаж байна.

Зураг 2. “Савхан” бүжгийн хөдөлгөөний чадвар (үзүүлэлт бүрээр авч үзвэл).



Зураг 2-оос харахад, судалгаанд хамрагдсан хүүхдүүд савхан бүжгийн хөдөлгөөнийг бүтээлчээр хийх чадвар 51% ба 38.5% нь бүжгийн хөдөлгөөний эв дүйтэй, хөгжмийн ая хэмнэлд тохируулан гүйцэтгэх байдал өндөр байлаа. Хүүхдүүдийн 10.5% нь савхаа бариад үсрэх, найгах, догонцох г.м хөдөлгөөнүүдийг тогтмол хийж байгаа нь бидний судалгаанаас харагдалаа.

Бусад үзүүлэлтүүд 40%-80% гүйцэтгэлтэй байгаа нь хүүхдүүд тодорхой түвшинд бүжиглэх бэлтгэлтэй, хөдөлгөөнийг өөрөө зохион хийж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

ӨМӨЗО-ны ардын бүжиг нэг болох “Савхан” бүжгийн хөдөлгөөнөөр дамжуулан таван настай хүүхдийн хөгжмийн мэдрэмжийг бүтээлчээр хөгжүүлэх болон бусад эгшгийн өндөрлөг, хэмнэл, сонсгол давхар хөгжих үр дүнтэй судалгаа болсон гэж үзэж байна.

## Дүгнэлт

Эрдэмтэд дуу авиа нь хөгжмийн хэсгүүдийн нийлбэртэй холбоотой биш, харин элементийн харилцаа, холбоо, "...хүн нийгмийн хөгжлийн тодорхой үе шатуудад хүмүүсийн нээсэн урлагын шинжлэх ухааны бүтээл, түүний ололт нь оюуны сэтгэлгээний, сэтгэл санааны гайхамшиг юм" хэмээн үзсэн байна. (Герман) К.Орф, (Унгар) З.Кодай нар аялгуу, дуурьсахуйн ухаан (олон хоолойн), ноот бичлэг, хөгжмийн зэмсэг, бүх нийтийн хөгжмийн боловсролын онол арга зүй гэж үзжээ. Дээрх эрдэмтдийн үзэж байгаа нийтлэг санаа нь хөгжим бол хүний сэтгэлийг хөдөлгөж, оюун санаанд нөлөөлөх, авьяас, ур чадварыг хөгжүүлдэг урлаг хэмээн үзсэн байна.

Хүүхдийн бүтээлч сэтгэлгээг ардын бүжгийн хөдөлгөөнөөр хөгжүүлэхийн тулд / хөгжимт хөдөлгөөн ба хөгжүүлэх үйл ажиллагаа/-ны явцад "Савхан" бүжгийн аялгууг сонсоод хөдөлгөөнийг дүрслэн, төсөөлөн бодох, утга агуулга, шинж төрхийг тайлбарлах, өөр хөдөлгөөнөөр илэрхийлэх энгийн арга барилыг сурч, уламжлалт аргыг хослуулсан нь бидний судалгаа үр дүнтэй болсон. СӨНХ-ийн нас сэтгэхүйд тохирсон бүжиг, дуу, хэмнэл, хөдөлгөөнийг тодорхой зорилго чиглэлтэйгээр сургалтаа явуулж чадсан цагт хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх ажил амжилттай хэрэгжинэ гэдэг нь нотлогдлоо.

Сургалтын арга барилууд хоорондоо харилцан холбоотой хэрэглэгдэж байж хүүхдийн бүтээлч чадварыг хөгжүүлэх зорилтыг хангадаг учраас нэг хичээл дээр хэд хэдэн арга барилыг хослон хэрэглэх тохиолдол байдаг. Хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлог нийцүүлэн сургалтаа явуулж чадсан цагт хүүхдийн бүтээлч сэтгэлгээ хөгжиж байгаа нь судалгааны явцад харагдлаа. Бүжгийн хөдөлгөөнийг хийх явцадаа 5 настай хүүхдүүд өөрийн бодол санаагаар өөрчилж, хөдөлгөөн хийх байдал 70% нь байсан ч зарим хүүхдүүд хөгжмийн аянд үсэрч, харайх, гүйх, савхыг хооронд нь үрж дуу авиа гаргаж баярлах зэрэг сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл 30% нь харагдаж байна.

Хүүхэд бүжгийн хөдөлгөөнийг өөрчилж бүтээлчээр сэтгэх чадвар хөгжсөнөөр бусад хөгжим сонсох, дуулах, хөгжимдөх, хөгжмийн ая хэмнэлийн мэдрэмжид ахиц гарна гэж үзсэн таамаглал эрдэмтдийн үзэж байгаа нийтлэг санаатай батлагдсан гэж үзлээ. Үүнд: хөгжим бол хүний сэтгэлийг хөдөлгөж, оюун санаанд нөлөөлөх, авьяас, ур чадварыг хөгжүүлдэг урлаг юм.

## Ном зүй

n.d.). Retrieved from [https://creativecopywriterclub.blogspot.com/2012/11/blog-post\\_18.html](https://creativecopywriterclub.blogspot.com/2012/11/blog-post_18.html). [https://creativecopywriterclub.blogspot.com/2012/11/blog-post\\_18.html](https://creativecopywriterclub.blogspot.com/2012/11/blog-post_18.html). (2012).

Батдэлгэр, Ж. (2020). Бага насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар, : Би Си Ай.

Ветлугина, Н. К. (1983). Теория и методика музыкального воспитания В детском саду. . Москва: Академи.

Лхагвасүрэн, Ж. (1985,х.15). Цэцэрлэгийн хүүхдэд хөгжмийн боловсрол олгох арга зүй. Улаанбаатар: Соёмбо.

**Баримт:** БНХАУ-ын сурган хүмүүжилийн яам нь найруулга, (2013). 3-6 насны хүүхдийн сурлага ба хөгжилтийн зүглүүр. ӨМ-ын хэвлэлийн бүлэглэл, ӨМ-ын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо

**DEVELOPING CHILDREN'S CREATIVITY THROUGH  
POLE DANCE MOVEMENTS**  
**/On the example of a five-year-old child from Inner Mongolia/**

<sup>a</sup>Zayabat G., <sup>b</sup>Hayzning Z.

<sup>a</sup>Teachers school, MNUE;

<sup>b</sup>Head of Kindergarten in Khokh, Inner Mongolia

Corresponding author: zasaba@msue.edu.mn 

**Abstract**

The term creativity has been used in education for decades, but creativity is understood and interpreted in different ways by different disciplines and professionals. Creative ideas don't have to be original, anyone's ideas can be anyone's. However, adding your own thoughts is the basis of increasing a person's independence. Psychologists believe that all children with normal development have creative abilities. Not all intelligent people are creative. But it is opened and developed. Therefore, it is possible to know how the mental processes of young children are developing.

**Keywords**

Creativity, tap dancing, child development, movement, skills, listening to music